



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 292

ГЭЗЭНБЭТ 11

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын санал, Батлан хамгаалах яамны 2005 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/1769 тоот, Хууль зүй, дотоод хэргийн яамны 2005 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 3/1950 тоот, Онцгой байдлын ерөнхий газрын 2005 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 590 тоот, Гадаад хэргийн яамны 2005 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 09/2917 тоот албан бичгүүд болон Самбуу овогтой Даваадашийн тайлбар, Очирбат овогтой Батжаргалын өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад нэр дурдсан хүмүүсийг 2005-2006 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуульд Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.


2. Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Удирдлагын академид Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар суралцаж буй Далайхүү овогтой Ядамдоржийн суралцах хугацааг 1 жилээр сунгасугай.

3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан 2005 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 226 дугаар тушаалын Гадаад хэргийн яамны захиалгаар суралцах Самбуу овогтой Даваадаш, 2005 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 271 дүгээр тушаалын Үндэсний статистикийн газрын захиалгаар суралцах Эчирбат овогтой Батжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар суралцах Доржготов овогтой Эрдэнэбаатар, Дагваа овогтой Эрдэнэбат нартай холбогдолтой хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2005-226 тушаалд кодификаци хийгдэв

2005-271 тушаалд кодификаци хийгдэв



САЙД

П.ЦАГААН

0000101

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын  
2005 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн  
191 дугаар тушаалын хавсралт

2005-2006 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны  
их сургуульд суралцах хүмүүсийн нэрс

№	Овог нэр	Сургууль	Мэргэжил	Түвшин	Сурах жил	Захиалагч байгууллага
1	Очирбат Батжаргал	Австралийн Свинбурн Технологийн Их сургууль	Компьютерийн шинжлэх ухаан	Магистр	2	Үндэсний статистикийн газар
2	Гэндэнжав Баттөгс	ОХУ-ын Онцгой байдлын яамны Галын аюулаас хамгаалах академи	Гамшигийн менежмент	Сонсогч	2	Онцгой байдлын ерөнхий газар
3	Жалцан Баянмөнх	ОХУ-ын Онцгой байдлын яамны Галын аюулаас хамгаалах академи	Гамшигийн менежмент	Сонсогч	2	Онцгой байдлын ерөнхий газар
4	Довдонцэрэн Ундрахболд	АНУ-ын Хойд Вирджинийн Их сургууль	Удирдлага	Магистр	2	Дээд шүүх
5	Сүхбаатар Болор-Эрдэнэ	Австралийн Masquarie Их сургууль	Санхүүгийн удирдлага	Магистр	2	Гадаад хэргийн яам
6	Батжаргал Нямдаваа	АНУ-ын Калифорнийн Улсын Их сургууль	Төрийн менежмент	Магистр	2	Батлан хамгаалах яам